



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 05

Хажуу шинэ ус

Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон
шалгаруулах тов зарлах тухай

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх хяналт тавих журам”-ын 2 дугаар зүйлийн 2.10 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит арвангуравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:


1. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хүлээн авах ажлыг 2024 оны 03 дугаар сарын 01 -ны өдрөөс эхлэн 2024 оны 04 дугаар сарын 01–ний хооронд зохион байгуулсугай.

2. Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтыг 2024 оны 04 дүгээр сарын 15–ны өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

3. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн санал хүлээн авах, сонгон шалгаруулахдаа журмын 2 дугаар зүйлийг мөрдлөг болгон ажиллахыг төсөл сонгон шалгаруулах хороо (Н.Өлзийтогтох)-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Булган)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ПҮРЭВСЭНГЭ

4824030005